



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/625

Есөнбулаг

Гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 6.2 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 40 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн төслийн хэрэгжүүлэгч 2 иргэнтэй зээлийн гэрээ байгуулан олгох эрхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т олгосугай.

2. Гэрээнд холбогдох хууль, журамд нийцүүлэн талуудын эрх үүрэг, хариуцлага, үндсэн зээл болон зээлийн хүүгийн эргэн төлөлтийн хуваарийг тодорхой тусгахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т үүрэг болгосугай.

3. Төслийн хэрэгжилт болон олгосон зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР